



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД  
ДУГНЭЛТ ӨГӨХ

ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН  
ОРЛОГЫГ 1,002.3 СЯА ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ, УРСГАЛ ЗАРДЛЫГ 1,275.5  
СЯА ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ, ТӨСВИЙН ҮР АШГИЙГ 10,314.5 СЯА ТӨГРӨГӨӨР  
НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА.

АУДИТЫН КОД: ЗАА-2024/03-12-НА-НА



Улиастай хот  
2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа  
Утас: 7046-3612, Цахим хаяг: [bat-undraad@audit.gov.mn](mailto:bat-undraad@audit.gov.mn)

Аудитын менежер Х.Болдбаатар  
Утас: 7046-3783, Цахим хаяг: [boldbaatarkh@audit.gov.mn](mailto:boldbaatarkh@audit.gov.mn)

Ахлах аудитор Ц.Оюунсүвд  
Утас: 99076038, Цахим хаяг: [oyunsuvdts@audit.gov.mn](mailto:oyunsuvdts@audit.gov.mn)

Аудитор Б.Мөнхнасан  
Утас: 90066888, Цахим хаяг: [munkhnasanb@audit.gov.mn](mailto:munkhnasanb@audit.gov.mn)

Аудитор Г.Баасанжаргал  
Утас: 99032514, Цахим хаяг: [baasanjargalg@audit.gov.mn](mailto:baasanjargalg@audit.gov.mn)

Шинжээч Ч.Ундармаа  
Утас: 80789109, Цахим хаяг: [undarmaach@audit.gov.mn](mailto:undarmaach@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг

**АГУУЛГА**

Тушаал ..... 2  
Товчилсон үгийн тайлбар.....3  
Хүснэгт, дүрслэл, хавсралтын товъёг.....3  
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, аудитын шалгуур үзүүлэлт, ерөнхий мэдээлэл.....4-5

**БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ 1,002.3 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.**

1.1. Орон нутгийн татварын орлогыг 4 нэр төрөлд 846.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.....6-9  
1.2. Татварын бус орлогыг 156.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.....9-10

**БҮЛЭГ 2. ЗАВХАН АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД УРСГАЛ ЗАРДЛЫГ 1,275.5 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ, ТӨСВИЙН ҮР АШГИЙГ 2,484.3 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА.**

2.1 Орон нутгийн төсвийн урсгал зардлыг 1,275.5 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.....11-16  
2.2 Орон нутгийн төсвийн үр ашгийг 2,484.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.....16-20

**БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХУУЛЬ, ЖУРМЫН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ, ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХГҮЙ 66 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД НИЙТ 7,830.2 САЯ ТӨГРӨГИЙГ ЗАРЦУУЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.**

3.1. Орон нутгийн хөрөнгө оруулалт, АОНХС-ийн хөрөнгөөр хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй 687.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй 2,656.5 сая төгрөгийн 21 төсөл арга хэмжээ, хууль, журмын чиг үүрэгт хамаарахгүй 5,173.7 сая төгрөгийн 45 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.....20-26

**ДҮГНЭЛТ** .....27  
**ЗӨВЛӨМЖ** .....28  
**АЙМГИЙН ИТХ-ЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**.....29-30



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/45

Улиастай

Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд  
дүгнэлт өгөх аудитын тайлан  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 18.10 дахь хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх" нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу төлөвлөгөө гарган ирүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацаанд ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэхийг шинжээч (Ч.Ундармаа)-д үүрэг болгосугай.

4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Ц.Оюунсүвд)-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т үүрэг болгосугай.



Д.БАТ-УНДРАА

013010113

**Товчилсон үгийн тайлбар**

<b>АДБОУС</b>	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ОНХНС</b>	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>ОНХО</b>	Орон нутгийн хөрөнгө оруулалт
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>БОАЖС</b>	Байгаль, орчин аялал жуулчлалын сайд
<b>ХБГ</b>	Хүлээгдэж буй гүйцэтгэл

**Хүснэгтийн товъёг**

<b>Хүснэгт-1</b>	Хог хаягдлын үйлчилгээний хураамж
<b>Хүснэгт-2</b>	Төсвийн орлого нэмэгдүүлэх саналын нэгтгэл
<b>Хүснэгт-3</b>	Орон нутгийн 2025 оны төсвийн зардал
<b>Хүснэгт-4</b>	Төсвийн зарлагын төслийг байгууллагад хуваарилсан байдал
<b>Хүснэгт-5</b>	Аймгийн ИТХ-ын нэмэгдсэн төсөв
<b>Хүснэгт-6</b>	Орон нутгийн төсвийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл
<b>Хүснэгт-7</b>	Нэмэгдсэн орон тооны мэдээлэл
<b>Хүснэгт-8</b>	Төсвийн урсгал зардал бууруулах саналын нэгтгэл
<b>Хүснэгт-9</b>	Хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөлт
<b>Хүснэгт-10</b>	Их засварын зардлын төлөвлөлт
<b>Хүснэгт-11</b>	Авто замын сангийн төлөвлөлт
<b>Хүснэгт-12</b>	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
<b>Хүснэгт-13</b>	Их засварын зардлаас зориулалт бус төлөвлөлт
<b>Хүснэгт-14</b>	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжих төсөл арга хэмжээ
<b>Хүснэгт-15</b>	ОНХО-ын зардлаас хууль, журмын чиг үүрэгт хамаарахгүй төсөл арга хэмжээний төлөвлөлт
<b>Хүснэгт-16</b>	ОНХО-ын зардлаас хуульд заасан чиг үүрэгт хамаарахгүй төсөл арга хэмжээний төлөвлөлт
<b>Хүснэгт-17</b>	Төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх саналын нэгтгэл

**Дүрслэлийн товъёг**

<b>График-1</b>	Төсвийн орлогын эх үүсвэрийн бүтэц
<b>График-2</b>	Малын тоо толгойн албан татвар
<b>График-3</b>	Ан, амьтны нөөц ашигласны төлбөр
<b>График-4</b>	Хүү, торгуулийн орлого
<b>График-5</b>	Өөрийн орлогын гүйцэтгэл

<p><b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b></p>	<p>Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/152, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/100 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.5.1 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт өгөх аргачлал”-ын дагуу гүйцэтгэлээ.</p>
<p><b>Аудитын зорилт</b></p>	<p>Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт өгч, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтыг хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төсвийн төсөлд орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх боломжийг тусгасан эсэх;</li> <li>- Төсвийн төсөлд зардал бууруулах болон төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломжийг тусгасан эсэх;</li> <li>- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль журмын шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн эсэх;</li> </ul>
<p><b>Аудитын хамарсан хүрээ</b></p>	<p>Аудитад аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтэс, аймгийн Татварын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс болон холбогдох бусад орон нутгийн төсөвт байгууллагуудын 2025 оны төсвийн төсөл, ТЭЗ-ийн нэгтгэсэн төсвийн төсөл, хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, 2025 оны орон нутгийн татварын орлогын Сангийн яамны хянасан төлөвлөгөө, 2024 оны төсвийн зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэл зэргийг хамрууллаа. Аймгийн Засаг дарга нь төсвийн саналыг холбогдох шаардлагад нийцүүлэн нэгтгэн боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх үүрэгтэй. Засаг даргаас аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн 2025 оны төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.</p>
<p><b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b></p>	<p>Аудитыг АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалт хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга</p>

**Аудитын багийн  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

авах зэрэг горимыг хэрэгжүүлэн, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан, зөвлөмж бэлтгэлээ.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хянан удирдаж, аудитын менежер Х.Болдбаатар үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитор Б.Мөнхнасан, Г.Баасанжаргал, Л.Гансүлд нар аудитыг гүйцэтгэлээ.

Аудитыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлүүлж, хөтөлбөрт заасан хугацаанд холбогдох үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын тайланг 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн дотор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Завхан аймгийн Засаг даргаас 2025 оны орон нутгийн төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн хязгаараас урсгал зардлыг 15,172.5 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 478.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зарлагыг 101,944.9 сая төгрөгөөр төлөвлөж, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 62,804.6 сая төгрөгөөр, орон нутгийн татварын болон татварын бус орлогоос 25,100.0 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгээс 14,040.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлсэн байна. Энэ нь төрийн албан хаагчдын цалин, дулааны үнэ тариф нэмэгдсэн, дотоод албан томилолтын тариф шинэчлэгдсэнтэй холбоотой байна. Харин хангамж, бараа материал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардал зэрэг урсгал зардлыг хийсвэрээр, хэт өндөр төлөвлөсөн гэж үзэхээр байна.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Завхан аймгийн 2025 оны төсвийн нийт зарлагыг 99,390.5 сая төгрөгөөр баталснаас, ОНХС-ийн орлогын шилжүүлгээс 17,294.8 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 53,224.5 сая төгрөг, орон нутгийн татварын болон татварын бус орлогоос 28,871.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

Завхан аймгийн 2025 оны төсвийн төслийг үр дүнд суурилсан төсөвлөлтөөр, Сангийн яамнаас ирүүлсэн “Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл”-ийг баримтлан төлөвлөж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 11 сарын 15-ны өдрийн 7/1103 дугаар албан бичгээр ирүүлсэн.

График-1



**БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ 1,002.3 СЯЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.**

**1.1. Орон нутгийн татварын орлогыг 4 нэр төрөлд 846.3 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 156.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.**

**1.1.1. Орон нутгийн татварын орлогыг 4 нэр төрөлд 846.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.**

Аймгийн 2025 оны төсвийн суурь орлогыг 25,100.0 сая төгрөгөөр төлөвлөн Сангийн яаманд хүргүүлж, 28,871.3 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

Сангийн яамнаас орон нутгийн татварын суурь орлогыг өмнөх оноос 32.3 хувиар буюу 9,340.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 28,871.3 сая төгрөгөөр хянасан байна. Татварын орлого 27,327.4 сая төгрөг буюу 94.6 хувийг, татварын бус орлогыг 1,543.8 сая төгрөг буюу 5.3 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутгийн татварын орлогын гүйцэтгэл 2024 оны 10 сарын 30-ний байдлаар 9,145.5 сая төгрөг буюу 61.2 хувиар давсан үзүүлэлттэй, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 9,065.5 сая төгрөг буюу 46 хувиар давж биелэхээр тооцсон байна.

***Орон нутгийн төсвийн орлогыг төсвийн шатлалаар авч үзвэл:***

*Аймгийн татварын орлогоор 2024 онд 2,136.7 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна. 2024 оны 10 сарын 31-ний байдлаар аймгийн төсвийн орлого 743.2 сая төгрөг буюу 38.9 хувиар давж биелсэн байна. ХБГ-ээр 743.2 сая төгрөг 34.8 хувиар давж биелэхээр тооцоолсон байна.*

*Сумын татварын орлогоор 2024 онд 17,587.0 сая төгрөг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. 2024 оны 10 сарын 31-ний байдлаар 8,402.3 сая төгрөг буюу 64.5 хувиар давж биелсэн үзүүлэлттэй байна. Харин ХБГ-ээр 8,322.3 сая төгрөг буюу 47.3 хувиар давж биелэхээр тооцоолсон байна.*

Төсвийн орлогын гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр судалж үзэхэд 4 нэр төрөл буюу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр, ахуйн хэрэглээний ус, рашаан ашигласны төлбөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны нөөц ашигласны төлбөр зэрэг орлогууд тасрах эрсдэлтэй байна.

Аудитаар орон нутгийн татварын орлогыг 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төлөвлөгөө, хүлээгдэж буй гүйцэтгэл болон 2025 оны Сангийн яамны хянасан төлөвлөгөөтэй харьцуулан тооцоолоход дараах нэр төрлийн орлогыг нэмэгдүүлэх боломж байна. Үүнд:

**- Малын тоо толгойн албан татвар:** Тус татварын хувь хэмжээг баталсан сумдын ИТХ-ын тогтоол, мөн аймгийн Статистикийн хэлтсээс 2023 оны жилийн эцэст тоологдсон малын тоог сумдаар авч, 2024 оны эхний хагас жилийн байдлаар тоологдсон малын тоо болон бойжсон төлийн тоонд үндэслэн сумдын татварын орлогын 2024 оны 10 сарын 31-ний өдрөөрх гүйцэтгэлийн мэдээний малын тоо толгойн албан татварын орлоготой уялдуулан тооцооллыг хийхэд аймгийн хэмжээнд зарж борлуулах, үрэгдэх, хоол хүнсэнд хэрэглэх гэх мэт хорогдол, зарлагыг хасаж тооцоолоход 1,185.7 сая төгрөгийн албан татвар ногдохоор байна.

График-2




2024 онд аймгийн ИТХ-ын шийдвэрлэсэн нэмэлт даалгавраар 500.0 сая төгрөгийг нэмэгдүүлэх орлогын төлөвлөгөө батлагдсанаас аймгийн Татварын газрын 2024 оны 10 сарын гүйцэтгэлээр 416.5 сая төгрөг, ХБГ-ээр 647.9 сая төгрөг төвлөрөхөөр байна. 2024 оны төлөвлөгөөг ХБГ-тэй харьцуулахад 129.6 хувиар буюу 29.6 хувиар давж биелэхээр байна. Харин байгалийн гамшигт үзэгдэл, хүчтэй салхи шуурга, цас зуд зэрэг байгаль, цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдлаас үүдэлтэй малын бэлчээр хүрэлцээгүй, отор нүүдэл ихтэй, өвөлжилт, хаваржилт хүндрэлтэй зэргийг харгалзан, мөн өмнөх онуудын татварын өр төлбөрийг тооцоололгүйгээр 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэлд үндэслэн ногдуулбал зохих 1,185.7 сая төгрөгийн татварын орлогын 55 орчим хувиар тооцоход 661.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна. Сумдын ЗДТГ малын тоо толгойн татварыг төвлөрүүлэх ажлыг хангалттай хэмжээнд зохион байгуулдаггүй, цаашид албан татварыг төвлөрүүлэх ажилд багийн Засаг дарга нар, сумдын ЗДТГ-ын хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийг татан оролцуулбал энэ төрлийн татвар бүрэн биелэх боломжтой юм.

**- Галт зэвсгийн албан татвар:** Галт зэвсгийн албан татварын хамгийн бага хэмжээ болох 30.0 мянган төгрөгөөр тооцож үзвэл ан агнуурын зориулалттай буюу 6,4 мм хүртэлх калибрын бүх төрлийн галт зэвсэг  $2663 \times 30.0 = 79.9$  сая төгрөгийн орлого төвлөрөх боломжтой байна. Галт зэвсгийн албан татвар 2018-2022 онд давж биелсэн үзүүлэлттэй боловч 2021-2023 онд тус албан татварын төлөвлөгөө өссөнөөр тасарсан байна. 2024 оны 10 сарын байдлаарх орлогын гүйцэтгэлийг харахад 87.1 хувь буюу 6.9 сая төгрөгөөр тасарсан байна. Аймгийн Татварын газар болон Цагдаагийн газрын хамтын ажиллагааг сайжруулж, галт зэвсэг эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжүүдийг татвараа хугацаанд нь төлөх талаар сурталчилгаа мэдээллийг цахимаар хийх зэрэг арга хэмжээг авч, орлогыг бүрэн төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Дээрх тооцоололд урьд онуудын өрийн судалгааг тооцоолоогүй бөгөөд 2025 онд ногдуулсан татвараа бүрэн төвлөрүүлнэ гэж үзвэл Сангийн яамны хянасан 2025 оны төлөвлөгөө 56.0 сая төгрөг дээр тооцоолсон боломжоос Сангийн яамны хянасан тоог хасаж, 23.9 сая төгрөгийн 20 хувиар 5.0 сая төгрөгийг нэмэх боломжтой байна.

**- Ан, амьтны нөөц ашигласны төлбөр:** Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн 2022, 2023 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2024 оны төлөвлөгөө, 10 дугаар сарын байдлаарх гүйцэтгэлийг графикаар харуулахад дараах байдалтай байна.

График-3



2024 онд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаараар 10 суманд бор гөрөөс 5, зэрлэг гахай 9, саарал чоно 15, шар үнэг 5, харин 18 ААНБ-д 29 толгой амьтныг тусгай зориулалтаар агнах зөвшөөрөл олгосон байна. 2025 онд Сангийн яамны хянасан орлого 201.5 сая төгрөг байгаа бөгөөд сүүлийн 3 жил орлогын төлөвлөгөө давсан, өмнөх онд 159.3 сая төгрөгийн төлөвлөгөөг 2024 оны ХБГ-тэй харьцуулахад 194.8 хувиар давж биелсэн байна. Ан агнуур БОАЖС-ын зөвшөөрлөөр олгогддог хэдий ч 2024 оны гүйцэтгэл, гадаадын иргэдэд олгох болон ахуйн зориулалтаар агнах тоо хэмжээний өсөлт болон долларын ханш нэмэгдэх зэрэгт үндэслэн 2025 оны суурь орлого дээр 116.2 сая төгрөгийн 35 хувиар буюу 40.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.

- **Хог хаягдлын үйлчилгээний хураамж:** Тус орлогын 2022, 2023 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2024 оны төлөвлөгөө, 10 сарын байдлаарх гүйцэтгэл, ХБГ-ийг хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт-1

Хугацаа	Хог хаягдлын үйлчилгээний хураамж		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
2022 он	150,000.0	162,842.5	108.6%
2023 он	150,000.0	106,838.2	71.2%
2024 оны 10 сар	300,000.0	79,386.4	26.4%
2024 оны ХБГ	300,000.0	254,456.4	84.8%

2023 онд хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 150.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 43.2 сая төгрөгөөр буюу 28.8 хувиар тасарсан бол 2024 онд 300 сая төгрөгөөр төлөвлөж, 10 сарын байдлаар 220.6 сая төгрөгөөр буюу 73.5 хувьтай байна. Энэ нь холбогдох албан тушаалтнууд сумын ИТХ-ын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаагүйтэй холбоотой байна.

Сангийн яамны 2025 оны хянасан төлөвлөгөөгөөр суурийг өмнөх оноос 190.0 сая төгрөгөөр буюу 63.3 хувиар бууруулж, 110.0 сая төгрөгөөр баталсан байна. Сумдаас тогтоосон ИТХ-ын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн үнэ тариф, хэмжих нэгж болон үйл ажиллагааны төрлүүд нь сум тус бүр дээр өөр тогтоогдсоны улмаас судалгаа хийхэд хүндрэл учирч байна. Мөн судалгааг зөвхөн энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг айл өрхөөр тооцоолж гаргасан бөгөөд эдгээр болон эдгээрээс бусад үйлчилгээний төрөл, чиглэлүүд дээр ИТХ-аас тогтоосон үнэ тарифаар сар бүр хураамжийг тогтмол хурааж ажиллавал энэ төрлийн хураамж

нэмэгдэх бүрэн боломжтой байна. 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэлээс харахад хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого тасарсан харагдаж байгаа ч сумд Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.6, 41.7 дахь заалт, нэг өрхөд ногдох хог хаягдлын хураамжийг тогтоосон сумдын ИТХ-ын тогтоолын үнэ тарифаар тооцоолоход 676.0 сая төгрөг төвлөрөх боломжтой байна. Орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлэх саналд Хог хаягдлын хураамжийг тооцоолсон орлогын 20 хувиар буюу 140.0 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой гэж үзлээ.

**1.2. Татварын бус орлогыг 156.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.**

**1.2.1. Татварын бус хүү, торгуулийн орлогыг 131.0 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 25.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.**

- **Хүү, торгуулийн орлого:** Хүү торгуулийн орлогын 2023 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2024 оны төлөвлөгөө, 10 сарын байдлаарх гүйцэтгэлийг графикаар харуулахад дараах байдалтай байна.

График-4



Хүү, торгуулийн орлого нь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Онцгой байдлын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хяналт шалгалтын торгуулийн орлого, аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, бусад Улсын байцаагчийн торгуулийн орлого, бусад нэр заагдаагүй орлого буюу актын төлбөрүүд (төрийн аудитын газар, санхүүгийн хяналт, дотоод аудитын алба), ой модтой сумдад торгуулийн орлогоос бүрдэж байна. Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр харьцуулахад 2022 онд 800.0 сая төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэл 1,222.1 сая төгрөгөөр буюу 252.8 хувиар давсан, 2023 онд 1,480.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 874.2 сая төгрөгөөр буюу 59 хувиар давж байсан бол 2024 онд аймагт 834.6 сая төгрөгөөр, сумдад 329.0 сая төгрөгөөр төлөвлөж, 2024 оны 10 сарын байдлаар аймагт төвлөрөх хүү, торгуулийн орлогын гүйцэтгэл 43.7 хувь буюу 516.2 сая төгрөгөөр, сумдад төвлөрөх хүү, торгуулийн орлогын гүйцэтгэл 42.1 хувь буюу 213.4 сая төгрөгөөр давсан байна. Тус орлого хүлээгдэж буй гүйцэтгэлээр 729.6 сая төгрөгөөр буюу 63 хувиар давж биелэх тооцоололтой байна.

Сангийн яамны 2025 оны хянасан төлөвлөгөөгөөр хүү торгуулийн орлогын суурийг өмнөх оноос 372.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1,536.8 сая төгрөгөөр баталсан ч хүү, торгуулийн орлого сүүлийн 3 жил 59-252.8 хувиар давж биелсэн тул тус

## ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

орлогыг 2024 оны 10 сарын байдлаарх гүйцэтгэлд үндэслэн 131.0 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой гэж үзэж байна.

- **Төсөвт байгууллагын өөрийн орлого:** Аймгийн ЗДТГ-ын өөрийн орлого нэмэгдэх боломжийг судлахад архивын үйлчилгээний орлогыг төлөвлөж, зарцуулах боломжтой байна. Архивын үйлчилгээний орлого 2023 онд 18,133.7 мянган төгрөг, 2024 онд 18,192.6 мянган төгрөгийн орлого бүрдсэн байна. Тус байгууллагын өөрийн орлогын гүйцэтгэл 2023 онд 7,438.8 мянган төгрөгөөр, 2024 оны 11 сарын 25-ны байдлаар 8,451.6 мянган төгрөгөөр тасарсан ч архивын орлогоос нөхөх боломж байна. Мөн өөрийн орлогыг 10.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

- Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төвийн өөрийн орлогын 2023 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2024 оны төлөвлөгөө, 11 сарын 25-ны байдлаарх гүйцэтгэлийг графикаар харуулахад дараах байдалтай байна.

График-5



Дээрх графикаас харахад тус байгууллагын өөрийн орлого 2023 онд 13.7 хувиар, 2024 оны 11 сарын 25-ны байдлаар 17.7 хувиар давж биелсэн байна. Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төвийн өөрийн орлого бассейн, заал, сауны орлого, аэробэк, фитнесын түрээсийн орлогоос бүрдэж байна. Сүүлийн 2 жилийн давсан орлогын дунджаар тооцоолоход тус байгууллагын өөрийн орлого 15.0 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна

Хүснэгт-2

### Төсвийн орлого нэмэгдүүлэх саналын нэгтгэл

д/д	Татварын нэр төрөл	Нэмэгдүүлэх санал (сая төгрөг)
1	Малын тоо толгойн албан татвар	661.3
2	Галт зэвсгийн албан татвар	5.0
3	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	40.0
4	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	140.0
5	Хүү, торгуулийн орлого	131.0
6	Төсөвт байгууллагуудын өөрийн орлого	25.0
<b>ДҮН</b>		<b>1,002.3</b>

**БҮЛЭГ 2. ЗАВХАН АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД УРСГАЛ ЗАРДЛЫГ 1,275.5 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ, ТӨСВИЙН ҮР АШГИЙГ 2,484.3 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА.**

**2.1. Орон нутгийн төсвийн урсгал зардлыг 1,275.5 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.**

**2.1.1. Орон нутгийн төсвийн урсгал зардлыг Сангийн яамны хянасан дүнгээс 12,745.9 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн боловч зарим урсгал зардлыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн байна.**

Завхан аймгийн 2025 оны төсвийн суурь зарлага өмнөх оноос 24,982.8 сая төгрөгөөр буюу 30.4 хувиар өссөн байна. Төсвийн нийт зарлага өсөхөд цалин, НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, тээвэр шатахууны зардал, хөрөнгийн зардал нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

Орон нутгийн 2025 оны төсвийн зарлагыг УИХ-аас баталсан дүнгээс нэмэгдүүлээгүй, 82,095.8 сая төгрөгөөр батлуулахаар төлөвлөсөн байна. Үүнээс урсгал зардлыг 12,745.9 сая төгрөгөөр бууруулж, 61,718.7 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 12,745.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 20,377.1 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Хүснэгт-3

**Орон нутгийн 2025 оны төсвийн зардал**

/сая.төгрөг/

Үзүүлэлт	УИХ-аас баталсан	2025 оны төсвийн төсөл	Зөрүү
Урсгал зардал	74,464.6	61,718.7	-12,745.9
Хөрөнгийн зардал	7,631.2	20,377.1	12,745.9
<b>Нийт зардал</b>	<b>82,095.8</b>	<b>82,095.8</b>	<b>-</b>

Засгийн газраас эрчим хүчний салбарын шинэчлэлийг хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор орон нутгийн өмчийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг нэмэгдсэн үнэ тарифаар тооцож, орон нутгийн суурь зардалд тусгасан байна.

Аймгийн 2025 оны урсгал зардлын төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамнаас ирүүлсэн орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлийн дагуу байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг дахин тооцоолж, Эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарын төсөвт байгууллагуудын тогтмол зардлыг УИХ-аас баталсан хязгаараас 5,698.0 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн нь үндэслэлтэй байна гэж үзлээ.

**Төсвийн зарлагын төслийг байгууллагад хуваарилснаар авч үзвэл:**

Хүснэгт-4

/сая төгрөг/

№	Хөтөлбөрийн ангилал	2024 оны тодотгосон төсөв	УИХ-ын баталсан төсөв	2025 оны төсвийн санал	Хэтрэлт Хэмнэлт
1	Аймгийн ИТХ	1,288.0	1,057.4	2,221.7	1,164.3
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	230.9	440.0	440.0	-
2	Аймгийн ЗДТГ	6,152.8	7,203.9	5,947.6	-1,256.3
	Засаг даргын нөөц сан	1,996.0	1,060.0	1,060.0	-
3	Сумын ИТХ	3,435.6	5,888.1	5,014.9	-873.2
4	Сумын ЗДТГ	19,294.0	25,346.9	20,985.1	-4,361.8

**ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ**

5	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	442.6	467.6	430.7	-36.9
6	Орон нутгийн өмчийн газар	434.9	367.1	522.9	155.8
7	Худалдан авах ажиллагааны газар	364.3	366.5	447.3	80.8
	БОАЖГазар	2,250.1	2,835.3	2,766.6	-68.7
8	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ	91.0	650.0	650.0	-
9	Ойжуулалт /ойн ангиуд/	351.7	419.5	463.7	44.2
10	Хот тохижилт үйлчилгээний алба	1,305.9	1,968.7	1,968.7	-
11	Баруун бүсийг олимпод бэлтгэх төв	994.6	1,041.6	1,098.3	56.7
12	Эрүүл мэндийн салбарын тогтмол зардал	2,974.0	5,965.6	3,418.9	-2,546.7
13	Боловсролын салбарын тогтмол зардал	9,643.2	15,118.4	11,786.9	-3,331.5
14	Мэргэжлийн боловсролын тогтмол зардал	817.9	1,055.5	873.3	-182.2
15	Соёл урлагийн тогтмол зардал	1,425.4	2,842.1	2,479.7	-362.4
16	Биеийн тамир, спортын салбарын тогтмол зардал	150.0	172.6	172.6	-
17	Засаг дарга данс	19.9			-
18	Мал эмнэлгийн үйлчилгээ	580.2	725.1	580.2	-144.9
19	Халамжийн сан	150.0	350.0	211.6	-138.4
20	Ахмадын хороо	256.6	121.1	298.0	176.9
21	Нийтийн тээврийн татаас	12.7	30.0	30.0	-
22	Замын сан	825.6	1,248.7	1,248.7	-
23	Их засвар	2,588.9	4,383.4	4,383.4	-
24	Орон нутгийн хөрөнгө оруулалт	10,150.6	2,680.7	14,745.0	12,064.3
	<b>Нийт дүн</b>	<b>65,909.5</b>	<b>82,095.8</b>	<b>82,095.8</b>	<b>-</b>

*Эх сурвалж: Завхан аймгийн 2025 оны төсвийн төсөв*

Аймгийн ИТХ-ын Сангийн яамнаас хянаж, УИХ-аас баталсан суурь зардлыг 1,164.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Үүнд: Хүснэгт-5

**Аймгийн ИТХ-ын нэмэгдсэн төсөв**

*/сая төгрөг/*

№	Зардлын төрөл	2024 оны тодотгосон	УИХ-аас баталсан	2025 оны төсвийн төсөлд тусгасан	Зөрүү /нэмэгдсэн/
1	Цалин	248.6	251.3	291.1	39.8
3	Унаа хоолны хөнгөлөлт	15.9	14.9	55.4	40.5
5	Аймгийн орлогоос төлөх НД-ын шимтгэл	60.1	65.9	74.3	8.4
6	Тээвэр шатахуун	63.5	74.2	82.5	8.3
10	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	470.1	135.0	895.5	760.5
12	Бараа үйлчилгээний бусад	56.6	100.0	213.5	113.5
15	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-	175.0	175.0
	<b>Нийт дүн</b>	<b>944.0</b>	<b>641.3</b>	<b>1,876.0</b>	<b>1,164.3</b>

*Эх сурвалж: Завхан аймгийн 2025 оны төсвийн төсөл*

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг үндэслэлгүйгээр өмнөх оноос 209.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах”, 4.2.3-д “хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх”, 4.2.7-д “аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул бууруулж, шаардлагатай хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд хуваарилах нь зүйтэй гэж үзлээ.

Мөн аймгийн ЗДТГ нь урсгал засварын зардалд 2024 оны төлөвлөгөөгөөр, үндэслэл, хэрэгцээ шаардлага, тооцоо судалгаагүйгээр 105.9 сая төгрөгийг нэмж төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3-д “үр ашигтай байх”, 4.1.7-д “бодитой байх”, 4.2.7-д “аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх” гэсэн заалттай нийцэхгүй байгааг бууруулж, шаардлагатай хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд хуваарилах нь зүйтэй байна.

Урсгал зардлыг 12,745.9 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн боловч тээвэр шатахууны зардлыг аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ-ын тээвэр шатахууны зардалд өмнөх оноос 41.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно”, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолтой нийцэхгүй тул тус зардлыг 41.6 сая төгрөгөөр бууруулах шаардлагатай байна.

2024 оны ХБГ-ээр орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл 85,540.7 сая төгрөг буюу 7,495.1 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Хүснэгт-6

**Орон нутгийн төсвийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл**

д/д	Хөтөлбөрийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт
1	Аймгийн ИТХ	1,288.0	1,188.9	99.1
2	Сумын ИТХ	3,860.2	3,546.9	313.3
3	Аймгийн ЗДТГ	6,152.8	5,369.6	783.2
4	Сумын ЗДТГ	21,954.7	21,800.3	154.4
5	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	442.6	411.8	30.8
6	Орон нутгийн өмчийн газар	434.9	430.4	4.5
7	Мал эмнэлгийн үйлчилгээ	580.2	580.2	0.0
8	Худалдан авах ажиллагааны газар	364.3	318.8	45.5
9	Авто тээврийн татаас	12.7	12.7	0.0
10	Авто зам	825.6	825.6	0.0
11	Ойжуулалт	351.7	339.7	12.0

**ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ**

12	БОАЖГазар	2,250.1	2,260.8	-10.6
13	Хот тохижилт	1,763.9	1,763.9	0.0
14	Эрүүл мэнд	2,982.1	2,976.3	5.8
15	Биеийн тамир	994.7	894.7	100.0
16	Соёл урлаг	1,425.4	1,389.9	35.5
17	СӨБ	2,098.0	2,046.2	51.8
18	ЕБС	7,544.8	7,770.0	-225.1
19	МСҮТ	817.9	813.3	4.6
20	Нийгмийн халамж	150.0	150.0	0.0
21	Ахмад настны хөгжил хамгаалал	256.6	256.6	0.0
22	ОНХС	20,762.3	19,907.3	855.0
23	СХС	2,832.8	1,181.5	1,651.3
24	Орон нутгийн хөрөнгө оруулалт	12,739.5	8,595.3	4,144.2
25	Нийгмийн эрүүл мэнд	150.0	150.0	0.0
	<b>ДҮН</b>	<b>93,035.8</b>	<b>85,540.7</b>	<b>7,495.1</b>

Хэмнэлтийн 88.7 хувь буюу 6,650.5 сая төгрөг нь орон нутгийн тусгай сан, орон нутгийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой байна.

Аудитаар орон нутгийн төсвийн урсгал зардлыг бууруулах дараах боломжууд байна гэж үзлээ. Үүнд:

- *Аймгийн ИТХ-ын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 350.0 сая төгрөгөөр, унаа, хоолны хөнгөлөлтийг 40.5 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 113.5 сая төгрөгөөр, урсгал зардлыг нийт 504.0 сая төгрөгөөр бууруулах;*
- *Аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ-ын тээвэр шатахууны зардлыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн, 41.6 сая төгрөгөөр бууруулах;*
- *Аймгийн Засаг даргын Тамгын газрын урсгал засварын зардлыг 105.9 сая төгрөгөөр бууруулах;*
- *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг 209.1 сая төгрөгөөр бууруулах;*

**2.1.2 Орон нутгийн төсөвт байгууллагуудын орон тоонд зохицуулалт хийж, чиг үүргийн давхардлыг арилган, ажил үүргийг нягтаршуулснаар урсгал зардлыг бууруулах боломжтой байна.**

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын орон тоог хянахад Сангийн яамнаас хянаж, УИХ-аас баталсан орон тооны хязгаарыг 22 орон тоогоор нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

*Хүснэгт-7*

№	Байгууллагын нэр	<i>Нэмэгдсэн орон тооны мэдээлэл</i>		
		<i>Сангийн яамнаас хянаж, УИХ-аас баталсан орон тоо</i>	<i>2025 оны төсвийн төсөлд тусгасан орон тоо</i>	<i>Зөрүү /нэмэгдсэн, хасагдсан/</i>
1	Аймгийн ИТХ	12	14	2
2	Аймгийн ЗДТГ	78	85	7
3	Орон нутгийн өмчийн газар	7	12	5
4	Худалдан авах ажиллагааны газар	7	11	4
5	Ойн анги	10	14	4
	<b>Нийт</b>	<b>114</b>	<b>122</b>	<b>22</b>

**Дээрх хүснэгтээс харахад:** Аймгийн ИТХ 2, аймгийн ЗДТГ 7, Орон нутгийн өмчийн газар 5, Худалдан авах ажиллагааны газар 4 орон тоо, Ойн ангиуд 4 орон тоо нэмж төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.2-д “чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”, 15.2-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэсэн заалттай нийцэхгүй, Засгийн газрын 2021 оны “Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай” 376 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоолыг баримтлаагүй байна. Иймд шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтаршуулах арга хэмжээ авч, Сангийн яамнаас хянасан орон тооны хязгаарыг баримтлан, төсвийн урсгал зардлыг бууруулах нь зүйтэй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль, эрх зүйн актуудтай нийцээгүй бүтэц, орон тоотой холбоотой зардал бууруулах дараах боломж байна. Үүнд:

- Сангийн яамнаас хянаж, УИХ-аас баталсан орон тооны хязгаар, Засгийн газрын 2021 оны 376 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн, аймгийн ИТХ-ын төлөвлөсөн орон тооноос 2 тоог хасаж, цалин, НДШ-ийн зардлыг 48.2 сая төгрөгөөр бууруулах;
- Сангийн яамнаас хянаж, УИХ-аас баталсан орон тооны хязгаар, Засгийн газрын 2021 оны 376 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн, аймгийн Засаг даргын Тамгын газрын төлөвлөсөн орон тооноос 7 орон тоог хасаж, цалин, НДШ-ийн зардлыг 168.0 сая төгрөгөөр бууруулах;
- Сангийн яамнаас ирүүлсэн орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлд Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Худалдан авах ажиллагааны газрыг ажиллуулахаар шийдвэрлэсэн. Тогтоолын хэрэгжилтийг хангаж 2025 оны орон нутгийн суурь зарлагад тус байгууллагыг үүсгэн, Орон нутгийн өмчийн газартай дүйцүүлэн 7 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар тооцон зардлыг тусгасан тул 2025 оны төсвийн төслөө боловсруулж батлуулахдаа Сангийн яамнаас хянасан орон тооноос хэтрүүлэхгүй байхад анхаарч ажиллах талаар дурдсан байна. Иймд аймгийн Худалдан авах ажиллагааны газрын төлөвлөсөн орон тооноос 4 орон тоог хасаж, 104.2 сая төгрөгөөр цалин, НДШ-ийн зардлыг бууруулах;
- Сангийн яамнаас хянаж, УИХ-аас баталсан орон тооны хязгаарыг баримтлан аймгийн Орон нутгийн өмчийн газрын төлөвлөсөн орон тооноос 4 орон тоог хасаж, цалингийн зардлыг 94.5 сая төгрөгөөр бууруулах;
- Тосонцэнгэл, Түдэвтэй сумдын ойн ангиудын орон тооны чиг үүргийн давхардал, ажлын ачааллыг нягтаршуулж, Сангийн яамнаас хянаж, УИХ-аас баталсан орон тооны хязгаарыг баримтлан 4 орон тоог бууруулах;

**ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ БУУРУУЛАХ САНАЛЫН НЭГТГЭЛ**

д/д	Зардлын ангилал	Зардал бууруулах (сая төгрөг)
1	Цалин, унаа, хоол, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл	455.4
2	Тээвэр, шатахууны зардал	41.6
3	Урсгал засвар	105.9
4	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	350.0
5	Бараа үйлчилгээний бусад зардал	113.5
6	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	209.1
<b>ДҮН</b>		<b>1,275.5</b>

**2.2. Орон нутгийн төсвийн үр ашгийг 2,484.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.**

**2.2.1. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд ач холбогдол багатай, үр ашиггүй, зориулалт бус 17.0 сая төгрөгийн урсгал зардлыг төлөвлөсөн байна.**

Их засвар, автозамын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас төлөвлөсөн төсөл арга хэмжээг авч үзэхэд дараах байдалтай байна.

№	Төсөл арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний тоо	УИХ-аас баталсан	2025 онд санхүүжих дүн
1.	Их засвар	23	4,383.4	4,383.4
2.	Авто замын сан	5	1,218.0	1,218.0
3.	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал /аймагт/	3	62.0	62.0
4	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал /сумдад/	-	588.0	588.0
<b>Нийт дүн</b>		<b>31</b>	<b>6,251.4</b>	<b>6,251.4</b>

- Их засвар: Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд их засварын зардлаар 4,383.4 сая төгрөгийн 23 төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр төлөвлөжээ.

ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

Хүснэгт-10

**Их засварын зардлын төлөвлөлт**

№	Төсөл арга хэмжээний нэр	2021-2025 оны үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эсэх	Төсөвт өртөг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал
1	Улиастай сумын Чигэстэй багт халуун ус нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулах	Тусгагдсан	450.0	ОНТ2
2	Улиастай сумын 7-р цэцэрлэгийн гадна талбайд тохижилт хийх	Тусгагдсан	60.0	ОНТ2
3	Баянтэс суманд нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулах	Тусгагдсан	600.0	ОНТ2
4	Улиастай сумын Товцог багт халуун ус, нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулах	Тусгагдсан	450.0	ОНТ2
5	Улиастай сумын 3-р цэцэрлэгийн гадна тоглоомын талбай байгуулах	Тусгагдсан	27.0	ОНТ2
6	Завханмандал сумын Төрийн байгууллагуудад хүүхдийн өрөө байгуулах	Тусгагдсан	87.0	ОНТ2
7	Тэлмэн сумын сургуульд биеийн тамирын талбай байгуулах	Тусгагдсан	180.0	ОНТ2
8	Улиастай сумын 4-р цэцэрлэгийн биеийн тамирын талбайг тохижуулах	Тусгагдсан	63.3	ОНТ2
9	Их-Уул сумын соёлын төвд тоног төхөөрөмж, "ЛЭД" дэлгэц авах	Тусгагдсан	80.0	ОНТ2
10	Шилүүстэй сумын соёлын төвд "ЛЭД" дэлгэц авах	Тусгагдсан	60.0	ОНТ2
11	Улиастай сумын Товцог багт халуун ус, нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулах		450.0	ОНТ2
12	Түдэвтэй сумын 20 ортой эмнэлгийн барилгад засвар хийх	Тусгагдсан	350.0	ОНТ2
13	Сантмаргаз сумын халуун усны барилгыг өргөтгөх	Тусгагдсан	400.0	ОНТ2
14	Тосонцэнгэл сумын хүүхэд хамгааллын төвд засвар хийх	Тусгагдсан	30.0	ОНТ2
15	Цагаанчулуут сумын цэцэрлэгийн барилгад засвар хийх	Тусгагдсан	30.0	ОНТ2
16	Цагаанчулуут сумын сургуулийн барилгад засвар хийх	Тусгагдсан	50.0	ОНТ2
17	Их-Уул сумын сургуулийн спорт заалны шалыг агч модон шал болгох	Тусгагдсан	91.0	ОНТ2
18	Отгон сумын сургуулийн дотуур байрыг засварлах	Тусгагдсан	350.0	ОНТ2
19	Тэс сумын ЕБС-ийн спорт заалны барилгын ажлыг дуусгах	Тусгагдсан	187.0	ОНТ2
20	Нөмрөг сумын спорт заалыг засварлах	Тусгагдсан	168.0	ОНТ2
21	Цэцэн-Уул сумын цэцэрлэгийн дотор сантехникийг засварлах	Тусгагдсан	72.0	ОНТ2
22	Улиастай сумын ЛЧЭС-ийн спорт заалны шалыг агч модон шал болгох	Тусгагдсан	93.0	ОНТ2

**ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ**

23	Улиастай Жавхлантай цогцолбор сургуулийн спорт заалны шалыг агч модон шал болгох	Тусгагдсан	95.0	ОНТ2
<b>Нийт дүн</b>			<b>4,383.4</b>	

**Дээрх хүснэгтээс харахад:** Их засварын зардлаас санхүүжих төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2021-2025 оны үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгаагаас харахад орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагад нийцсэн байна гэж үзэхээр байна.

**2. Авто замын сан:** Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд автозамын сангийн хөрөнгөөр 1,248.6 сая төгрөгийн 5 ажлыг гүйцэтгэхээр төлөвлөжээ. Үүнд:

*Хүснэгт-11*

**Автозамын сангийн төлөвлөлт**

*/сая төгрөг/*

№	Төсөл арга хэмжээний нэр	2021-2025 оны үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эсэх	Зураг төсөвтэй эсэх	Төсөвт өртөг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал
1	Авто замын сангийн хөрөнгөөр цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан нэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх	Тусгагдсан		926.0	ОНЗС
2	Улиастай сумын Богдын гол багийн Цагдаагийн 24 айлын орон сууцны гадна талд авто зогсоол хийх	Тусгагдсан	Зураг төсөвтэй	46.2	ОНЗС
3	Улиастай сумын Хөгжим бүжгийн 24 айлын орон сууцны гадна талд авто зогсоол хийх	Тусгагдсан	Зураг төсөвтэй	87.1	ОНЗС
4	Чигэстэй голын гүүрнээс Хайрхан дэлгүүр хүртэлх явган зам хийх	Тусгагдсан	Зураг төсөвтэй	62.4	ОНЗС
5	Улиастай сумын Богдын гол багийн 18-р байрны гадна талд авто зогсоол хийх	Тусгагдсан	Зураг төсөвтэй	96.3	ОНЗС
<b>Нийт</b>				<b>1,248.6</b>	

**1. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал**

*Хүснэгт-12*

*/сая төгрөг/*

№	Төсөл арга хэмжээний нэр	2021-2025 оны үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эсэх	Зураг төсөв, тооцоо судалгаагаар эсэх	Төсөвт өртөг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал
1	Аймгийн ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах	Тусгагдсан		22.0	БХНСАХЗ
2	Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнах боломжит загасны судалгаа хийх	Тусгагдсан		23.0	БХНСАХЗ
3	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавьж, бүсчилсэн сургалт зохион байгуулах	Тусгагдсан	Тооцоо судалгаагүй	17.0	БХНСАХЗ
4	24 сумдад	Тусгагдсан		588.0	БХНСАХЗ
<b>Нийт</b>				<b>650.0</b>	

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 588.0 сая төгрөгийг сумдад хуваарилж, аймагт 62.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас сургалт зохион байгуулахаар 17.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.2-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.4-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд Сангийн яамнаас ирүүлсэн “Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл”-ийг баримтлан, зориулалт бус үйл ажиллагаанд төлөвлөсөн 17.0 сая төгрөгийг журмын дагуу шаардлага хангасан төсөл арга хэмжээнд төлөвлөх шаардлагатай байна.

**2.2.2. Их засварын зардлаас хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй, зориулалт бус 2,467.3 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.**

Хүснэгт-13

**Их засварын зардлаас зориулалт бус төлөвлөлт**

№	Төсөл арга хэмжээний нэр	2021-2025 оны үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эсэх	Зураг төсөвтэй эсэх	Төсөвт өртөг	
1	Улиастай сумын Чигэстэй багт халуун ус нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулах	Тусгагдсан	Зураг төсөвгүй	450.0	Зориулалт бус
2	Улиастай сумын 7-р цэцэрлэгийн гадна талбайд тохижилт хийх	Тусгагдсан	ТЭЗҮ-гүй	60.0	Зориулалт бус
3	Баянтэс суманд нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулах	Тусгагдсан	Зураг төсөвгүй	600.0	Зориулалт бус
4	Улиастай сумын Товцог багт халуун ус, нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулах	Тусгагдсан	Зураг төсөвгүй	450.0	Зориулалт бус
5	Улиастай сумын 3-р цэцэрлэгийн гадна тоглоомын талбай байгуулах	Тусгагдсан	ТЭЗҮ-гүй	27.0	Зориулалт бус
6	Завханмандал сумын Төрийн байгууллагуудад хүүхдийн өрөө байгуулах	Тусгагдсан	ТЭЗҮ-гүй	87.0	Зориулалт бус
7	Тэлмэн сумын сургуульд биеийн тамирын талбай байгуулах	Тусгагдсан	Зураг төсөвгүй	180.0	Зориулалт бус
8	Улиастай сумын 4-р цэцэрлэгийн биеийн тамирын талбайг тохижуулах	Тусгагдсан	ТЭЗҮ-гүй	63.3	Зориулалт бус
9	Их-Уул сумын соёлын төвд тоног төхөөрөмж, "LED" дэлгэц авах	Тусгагдсан	-	80.0	Зориулалт бус
10	Шилүүстэй сумын соёлын төвд "LED" дэлгэц авах	Тусгагдсан	-	60.0	Зориулалт бус
11	Улиастай сумын Товцог багт халуун ус, нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулах	Тусгагдсан	Зураг төсөвгүй	450.0	Зориулалт бус
<b>Нийт дүн</b>				<b>2,467.3</b>	

**Дээрх хүснэгтээс харахад:** Их засварын зардлаас зураг төсөвгүй, зориулалт бус, аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой 2,467.3 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.4-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах”, 14.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 29 дүгээр зүйлийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3. “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.3. “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн яамнаас ирүүлсэн “Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл”-ийг баримтлан, их засварын зардлыг тухайн барилга, байгууламжийн насжилтыг уртасгах, их засварын шинжтэй ажлуудыг тусгаж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Автозамын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 1,248.6 сая төгрөгийн 5 төсөл арга, хэмжээ нь хууль, журмын шаардлагад нийцсэн байна.

Аудитаар орон нутгийн төсвийн үр ашгийг дээшлүүлэх дараах боломжууд байна. Үүнд:

- Их засварын зардлаас 2,467.3 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээг зориулалт бус үйл ажиллагаанд төлөвлөснийг бодит хэрэгцээ шаардлагад тулгуурлан тухайн барилга, байгууламжийн насжилтыг уртасгах, их засварын шинжтэй ажлуудад төлөвлөж төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх;

- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас сургалт зохион байгуулах 17.0 сая төгрөгийг шаардлага хангасан төсөл арга хэмжээнд төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх;

**БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХУУЛЬ, ЖУРМЫН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ, ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХГҮЙ 66 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД НИЙТ 7,830.2 САЯ ТӨГРӨГИЙГ ЗАРЦУУЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.**

**3.1. Орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй 687.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй 2,656.5 сая төгрөгийн 21 төсөл арга хэмжээ, хууль, журмын чиг үүрэгт хамаарахгүй 5,173.7 сая төгрөгийн 45 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.**

**3.1.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн 337.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 350.0 сая төгрөгийн мөн 2 төсөл арга хэмжээ нь аймаг, орон нутгийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцээгүй байна.**

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 14,745.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 106 төсөл арга хэмжээг, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 6,406.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт-14

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар  
2025 онд хэрэгжих төсөл арга хэмжээ**

№	Төсөл арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр	Төсөл арга хэмжээний тоо	УИХ-аас баталсан дүн	/сая.төгрөг/
				2025 оны төсвийн төсөлд
1.	Орон нутгийн хөрөнгө оруулалт	106	2,680.7	14,745.0
2.	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	35	6,406.5	6,406.5
3.	Сумдын Орон нутгийн хөгжлийн сан	-	10,888.3	10,888.3
<b>Нийт дүн</b>		<b>141</b>	<b>19,975.5</b>	<b>32,039.8</b>

2025 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүдийг аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдлыг шалгахад дараах төсөл хөтөлбөрүүд тусгагдаагүй байна. Үүнд:

- 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй аймгийн хэмжээнд "1000 ном" арга хэмжээ хэрэгжүүлэх;
- 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй аймгийн Нэгдсэн эмнэлэгт "Диабит"-ын төв байгуулах;
- 265.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй аймгийн Засаг даргын Тамгын газарт үйлчилгээний автомашин авах;
- 72.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Тосонцэнгэл суманд "Хөдөлмөрийн баатар Ш.Даваахүү"-гийн нэрэмжит үндэсний сурын талбайг тохижуулах;

**3.1.2. Орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2,656.5 сая төгрөгийн 21 төсөл арга хэмжээ нь хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй байна.**

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар батлагдсан зураг төсөвгүй 2,056.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсөвлөсөн байна.

Орон нутгийн 2025 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр хуулийн 29.4-д заасан шаардлагыг хангаагүй, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.3-т заасныг мөрдөөгүй Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 2,056.5 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээ, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 600.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээг тус тус төлөвлөсөн байна. Үүнд:

- 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ургамал сумын хогийн цэгийг хайслуулах;
- 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Их-Уул сумын ЕБС-д “Волейбол”-ын гадна талбай авах;
- 140.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Шилүүстэй сумын хогийн цэгийн хогийг дарж булах, хайсжуулалт хийх;
- 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Отгон сумын хогийн цэгийн хогийг дарж булах, хайсжуулалт хийх;
- 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Алдархаан суманд эмчийн байр барих;
- 87.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Алдархаан сумын Чигэстэй багт Иргэдийн хөгжлийн төв барих
- 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Дөрвөлжин суманд Эмчийн байр барих;
- 187.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Асгат суманд халуун усны барилга барих;
- 72.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хөдөлмөрийн баатар Ш.Даваахүүгийн нэрэмжит үндэсний сурын талбайг тохижуулах;
- 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сонгино суманд нийтийн халуун ус барих;
- 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны өрөөнүүдийг засварлах;
- 90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Аймгийн Цагдаагийн газрыг гаржийн дээврийн засвар хийх;
- 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хилийн цэргийн 0277 дугаар ангийн албан хаагчдын орон сууцны барилгыг барих;
- 210.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эрдэнэхайрхан суманд гэрэлтүүлэг хийх;
- 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Яруу суманд хадлангийн талбай хаших;
- 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг сургалтын төв болгох;
- 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Теле” хяналтын дэд төв байгуулах;
- 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Насан туршийн боловсролын төвөөр дамжуулан малчид, бизнес эрхлэгчид, хоршоологчдыг дэмжиж сургалтад хамруулах”;
- 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн музейн үзмэрийг баяжуулах”;
- 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хил дагуух аялал жуулчлалыг хөгжүүлэх”;
- 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Үндэсний их баяр наадам, ардын хувьсгалын 104 жил, аймаг үүсэн байгуулагдсаны 102 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх”;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 29 дүгээр зүйлийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”,

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.1.7-д “бодитой байх”, 4.2.3-д “хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх”, 4.2.7-д “аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд дээрх төсөл арга хэмжээнүүдийг хууль журмын шаардлага хангасан дараагийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд төлөвлөж хуваарилах нь зүйтэй байна.

**3.1.3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 1,930.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлийн тухай хууль зөрчсөн болон хөрөнгө оруулалтын шинжгүй 3,243.7 сая төгрөгийн 39 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.**

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, гадаад улс орнуудтай хийх хамтын ажиллагаа, түншлэлийг нэмэгдүүлэх, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэдийг мэдээллээр хангах, цэргийн насны залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах зэрэг төсвийн тухай “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын чиг үүрэгт хамаарахгүй 1,930.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

- 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Төрийн бус байгууллага, Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих;
- 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Завхан аймаг “Баруун бүсийн аялал жуулчлалын төв” болох зорилтыг хэрэгжүүлж “Шашны аялал жуулчлал”-ыг хөгжүүлэх;
- 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шашны аялал жуулчлал”-ыг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд контент хийх;
- 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Гадаад улс орнуудтай хийх хамтын ажиллагаа, түншлэлийг нэмэгдүүлж, олон талт арга хэмжээг зохион байгуулах, гэрээ санамж бичиг байгуулах;
- 1500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж орон сууцны дэмжлэг үзүүлэх;
- 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Орон нутагт зохион байгуулж буй онцлог үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд сурталчлах;

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийтийн эрх ашигт нийцсэн дэд бүтэц, орчны тохижилт хийх, байгаль орчныг хамгаалах, өрхийн орлогыг дэмжих, ажлын байр бий болгох зэрэг хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна. Иймд дээрх төсөл арга хэмжээнүүдийг хууль журамд нийцсэн дараагийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд төлөвлөж, төсвийн үр ашгийг 1,930.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 1,000.5 сая

**ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ**

төгрөгийн 6 төсөл арга хэмжээг, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй 2,049.8 сая төгрөгийн 26 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- 265.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Аймгийн Засаг даргын Тамгын газарт үйлчилгээний автомашин авах;
- 115.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг тоног төхөөрөмжөөр хангах;
- 120.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Насан туршийн боловсролын төвд автобус авах;
- 250.0 сая төгрөгөөр Их-Уул сумын ЖДҮ эрхлэгч, хоршоологчдыг тоног төхөөрөмжөөр хангах;
- 200.0 сая төгрөгөөр Нэг цэгийн үйлчилгээний төвийг сургалтын төв болгох;
- 50.0 сая төгрөгөөр Монгол Улсын гавьяат багш Б.Энхбаярын Байгалийн ухааны цогц хичээл буюу "Сургалтын хөдөлгөөнт үзүүлэн бэлтгэх төсөл"-ийг ерөнхий боловсролын сургуулиудад нэвтрүүлэх;

Дээрх төсөл арга хэмжээнүүдийг хууль журамд нийцсэн дараагийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд төлөвлөж, төсвийн үр ашгийг 1,000.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх шаардлагатай байна.

**Орон нутгийн хөрөнгө оруулалтаас шагнал урамшуулал, тэтгэлэг, дэмжлэг, сургалт зөвлөгөөн зэрэг арга хэмжээний зардалд шинжтэй дараах төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнд:**

*Хүснэгт-15*

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, цагаан сар, ахмадын өдрөөр ахмад настанд хүндэтгэл үзүүлэх	250.0
2	Тосонцэнгэл суманд ахмадын II чуулган зохион байгуулах	30.0
3	Аймгийн зүүн бүсийн сумдын нийтлэг үйлчилгээ эрхлэгчдийн зөвлөгөөн зохион байгуулах	20.0
4	Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж амралт, рашаан сувилалд амраах	240.0
5	Амжилт гаргасан оюутнуудад аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгох	50.0
6	Олимпиад, ЭЕШ-д эхний байр эзэлсэн хүүхэд, багш нарыг дэмжих	50.0
7	Бүс, Улс, ОУ-ын тэмцээнд оролцож амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдыг шагнаж урамшуулах	30.0
8	Аймгийн Засаг даргын дэргэдэх "Өсвөрийн шигшээ баг"-ийн үйл ажиллагааг дэмжиж, уралдаан тэмцээн зохион байгуулж Улс, Бүс, ОУ-ын тэмцээнд тамирчдыг оролцуулах	100.0
9	"Оройн чимэг", "Дуртмал энхийн дугараа" уртын дууг түгээн дэлгэрүүлэх хадгалан хамгаалах зорилгоор МУГЖ Б.Лхамжав агсны нэрэмжит уртын дууны ОУ-ын уралдаан зохион байгуулах	100.0
10	Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого зохион байгуулах	12.0
11	Улс, аймгийн аварга малчин, тариаланч, алдарт уяач шалгаруулж хүндэтгэл үзүүлэх	100.0
12	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих	500.0
13	Тосонцэнгэл суманд аялал жуулчлалын форум зохион байгуулах	40.0
14	"Шашны аялал жуулчлал"-ыг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд "Төгс Буянт Жавхлантай" хийдийн үйл ажиллагааг дэмжиж арц, хүжний үйлдвэрийн тоног төхөөрөмж авах	200.0

**ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ**

15	"Төрийн үйлчилгээг багт" арга хэмжээ зохион байгуулах	90.0
16	Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдыг чадавхжуулж, хөгжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх	100.0
17	Иргэд, Төрийн албан хаагчдад эрх зүйн сургалт, сурталчилгаа явуулах	9.6
18	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх	9.7
19	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, зөвлөмжийн нийцлийг бүрэн хангах сургалт зохион байгуулах	8.0
20	Төрийн архивын удирдлагын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн санд оруулах	31.0
21	Төрийн хяналт шалгалтыг салбар бүрд зохион байгуулах, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах	17.0
22	Зэвсэгт хүчний 104 жилийн ой, Чөлөөлөх дайны ялалтын 80 жилийн ой, генерал цол бий болсны 81 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх	10.0
23	Хяналтын тоонд багтаан хугацаат албаны цэрэг татлагыг 2 удаа зохион байгуулах	20.0
24	Хугацаат цэргийн алба хаагчдын албаны үйл ажиллагаатай танилцах, тэдний ар гэрт дэмжлэг үзүүлэх	20.0
25	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын сургалт зохион байгуулах	8.0
26	Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалт зохион байгуулах	4.5

**Нийт дүн 2,049.8**

Орон нутгийн хөрөнгө оруулалтаас зарцуулахаар төлөвлөсөн дээрх 2,049.8 сая төгрөгийг шаардлагатай хөрөнгө оруулалтын зардалд төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Мөн Улсын төсөвт байгууллагуудад тоног төхөөрөмж бэлтгэхээр 193.4 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Үүнд:

*Хүснэгт-16*

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	Сум дундын Прокурорын газарт тоног төхөөрөмж авах	19.5
2	Аймгийн Прокурорын газарт ухаалаг дэлгэц авах	15.0
3	Цагдаагийн албан хаагчдад энгэрийн камер, тоног төхөөрөмж авах	20.0
4	Цагдаагийн алба хаагчдыг торгуулийн багаж, хэвлэгч, тоног төхөөрөмжөөр хангах	42.9
5	Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааг дэмжиж тоног төхөөрөмж авах	10.0
6	24 сумын Мал эмнэлгийн мэргэжилтнүүдийн компьютер тоног төхөөрөмж	50.0
7	Аймгийн итгэмжлэгдсэн лабораторийн багаж тоног төхөөрөмжийг сайжруулах	36.0
<b>Нийт дүн</b>		<b>193.4</b>

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд тус зардлыг шаардлагатай хөрөнгө оруулалтын зардалд төлөвлөж, орон нутгийн төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Мөн Орон нутгийн хөрөнгө оруулалтаас 1,200.0 сая төгрөгийн өмнөх оноос шилжих хөрөнгө оруулалтыг дуусгах ажлыг төсөл арга хэмжээгээр задлаагүй, бөөн дүнгээр төлөвлөснийг төсөл арга хэмжээ бүрээр төлөвлөх нь зүйтэй байна.

Төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах үйл ажиллагааг Монгол Улсын Төсвийн тухай хууль холбогдох эрх зүйн актууд, төсвийн төслийг боловсруулах,

## ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжид нийцүүлэн үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөхөөр зохицуулагдсан байдаг.

Гэтэл аймгийн 2025 оны төсвийн төсөлд их засвар, орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн ОНХС зэрэг хөрөнгө оруулалтын зардлыг зориулалт бусаар тэтгэмж, тэтгэлэг, дэмжлэг, шагнал, урамшуулал, сургалт, зөвлөгөөн зэрэгт зарцуулахаар хэт үрэлгэн төлөвлөсөн байна.

Хүснэгт-17

### ТӨСВИЙН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛЫН НЭГТГЭЛ

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Үр ашиг нэмэгдэх санал (сая төгрөг)	САНАЛ
1	Их засварын зардлаас хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй, зориулалт бус 11 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	2,467.3	Шаардлага хангасан дараагийн төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
2	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн	17.0	Шаардлага хангасан дараагийн төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
3	Орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй 21 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	2,656.5	Шаардлага хангасан дараагийн төсөл арга хэмжээнд төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
4	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 6 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	1,930.0	Журамд нийцсэн дараагийн төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
5	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлийн тухай хууль зөрчсөн болон хөрөнгө оруулалтын шинжгүй 39 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	3,243.7	Шаардлага хангасан дараагийн төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
	<b>ДҮН</b>	<b>10,314.5</b>	

**АУДИТААР ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ 6 НЭР ТӨРӨЛД 1,002.3 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОН УРСГАЛ ЗАРДЛЫГ 1,275.5 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ, ТӨСВИЙН ҮР АШГИЙГ 10,314.5 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛЫГ ХҮРГҮҮЛЛЭЭ.**

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогыг зарим нэр төрлийн татвараар нэмэгдүүлэх боломжтой байна.
2. Аймгийн 2025 оны төсвийн төсөлд Сангийн яамнаас хянаж, УИХ-аас баталсан орон тооны хязгаарыг 22 орон тоогоор нэмэгдүүлж төлөвлөсөн байна.
3. Орон нутгийн төсвийн урсгал зардлыг Сангийн яамны хянасан дүнгээс 12,745.9 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн боловч зарим төсөл, арга хэмжээг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэх зохицуулалт хийсэн байна.
4. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар автомашины хэрэглээг хязгаарласан байхад шатахууны зардлыг нэмэгдүүлэх зохицуулалт хийсэн байна.
5. Орон нутгийн төсвийн урсгал зардлыг 1,275.5 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.
6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймгийн ОНХС, хөрөнгөөр хууль, журамд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулах эрсдэлтэй байна.
7. Их засварын зардал болон Орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад хууль, журамд нийцээгүй, зориулалт бус, үр ашиггүй, хөрөнгө оруулалтын шинжгүй арга хэмжээний зардалд зарцуулахаар хэт үрэлгэн төлөвлөсөн байна.

**ЗӨВЛӨМЖ**

“Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” аудитын дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА Б.САНЖСҮРЭН-Д**

1. Хөрөнгө оруулалтын төсвийг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлах;

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.ӨНӨРБАЯР-Т**

1. Орон нутгийн төсвийн орлогыг 1,002.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;
2. Сангийн яамнаас батлагдсан орон тоог нэмэгдүүлэхгүй байх;
3. Орон нутгийн төсвийн урсгал зардлыг 1,275.5 сая төгрөгөөр бууруулах;
4. Төрийн хэмнэлтийн тухай хуульд хязгаарласан болон хэмнэхээр тусгасан зардлуудыг Сангийн яамны баталсан дүнгээс нэмэгдүүлэхгүй байх;
5. Хууль, журамд заасан шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн 2,656.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг дараагийн шаардлага хангасан төсөл арга хэмжээнд төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх;
6. Хууль, журамд нийцээгүй, зориулалт бус арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн 7,658.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг дараагийн шаардлага хангасан төсөл арга хэмжээнд төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх;

Аудитаар өгсөн зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу төлөвлөгөө гарган ирүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж, 2025 оны 01 дүгээр сарын 25-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

ЗАВХАН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 01

Улиастай

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Г.ӨНӨРБАЯР ТАНАА

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хурлын 2024 оны 11-р сарын 28-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

Төсвийн орлогыг 6 нэр төрлөөр 1.002.3 сая төгрөгийг нэмэгдүүлэх, төсвийн урсгал зардлыг 1.275.5 сая төгрөгөөр бууруулах, төсвийн үр ашгийг 10.314.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Х.Болдбаатар, ахлах аудитор Ц.Оюунсүвд нар танилцуулав.

Төсвийн орлого нэмэгдүүлэх саналын нэгтгэл

д/д	Татварын нэр төрөл	Нэмэгдүүлэх санал (сая төгрөг)
1	Малын тоо толгойн албан татвар	661.3
2	Галт зэвсгийн албан татвар	5.0
3	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	40.0
4	Хүү, торгуулийн орлого	131.0
5	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	140.0
6	Төсөвт байгууллагуудын өөрийн орлого	25.0
	<b>ДҮН</b>	<b>1,002.3</b>

УРСГАЛ ЗАРДАЛ БУУРУУЛАХ САНАЛ

д/д	Зардлын ангилал	Зардал бууруулах (сая төгрөг)
1	Цалин, унаа, хоол, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл	455.4
2	Тээвэр, шатахууны зардал	41.6
3	Урсгал засвар	105.9
4	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	350.0

ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

үйлчилгээний төлбөр хураамж

5	Бараа үйлчилгээний бусад зардал	113.5
6	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	209.1
<b>ДҮН</b>		<b>1,275.5</b>

ТӨСВИЙН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Үр ашиг нэмэгдэх санал (сая төгрөг)	САНАЛ
1	Их засварын зардлаас хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй, зориулалт бус 11 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	2,467.3	Шаардлага хангасан дараагийн төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
2	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн	17.0	Шаардлага хангасан дараагийн төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
3	Орон нутгийн хөрөнгө оруулалт, АОНХС-ийн хөрөнгөөр хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй 21 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	2,656.5	Шаардлага хангасан дараагийн төсөл арга хэмжээнд төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
4	АОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 6 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	1,930.0	Шаардлага хангасан дараагийн төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
5	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Төсвийн тухай хууль Төрийн хэмнэлийн тухай хууль зөрчсөн болон хөрөнгө оруулалтын шинжгүй 39 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	3,243.7	Шаардлага хангасан дараагийн төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
<b>ДҮН</b>		<b>10,314.5</b>	

Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан дараах шийдвэрийг тэмдэглэлээр гаргав. Үүнд:

“Аудитын байгууллагаас төсвийн орлогыг нэмэгдүүлэх талаар оруулж ирсэн 6 нэр бүхий татварууд нь бодитой бус хэлбэлздэг, хувьсах орлого учраас орон нутгийн төсвийн 2025 оны суурь орлогыг 6 нэр төрлөөр 1.002.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр төсөвд тусгахыг түтгэлзэх, урсгал зардлыг 6 төрлөөр 1.275.5 сая төгрөгөөр бууруулж, төсвийн үр ашгийг 5 төрлөөр 10.314.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх талаар аудитын дүгнэлтийг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй” гэжээ...

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ЗӨВЛӨЛ